



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны 12 дугаар сарын 19-ний өдөр

Улаанбаатар хот

АВТОТЭЭВРИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Автотээврийн тухай хуульд дор дурдсан агуулгатай 6¹ дүгээр зүйл нэмсүгэй:

“6¹ дүгээр зүйл.Автотээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын бүрэн эрх

6¹.1.Автотээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

6¹.1.1.автотээврийн талаар төрөөс баримтлах бодлого болон хууль тогтоомжийн хэрэгжилтийг улсын хэмжээнд зохион байгуулж, биелэлтийг шалгах, дүнг

мэдээлэх;

6¹.1.2.улс хоорондын зорчигч болон ачаа тээвэр, нийтийн тээвэр, шуудан, жуулчин тээвэрлэлтийн үйлчилгээ болон автотээврийн хэрэгсэлд техникийн

хяналтын үзлэг хийх;

6¹.1.3.тээврийн хэрэгслийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан байгуулж, холбогдох байгууллагыг байнгын мэдээллээр хангах;

6¹.1.4.Монгол Улсын нутаг дэвсгэрт ашиглагдаж байгаа автотээврийн хэрэгслийн бүртгэлийг хөтлөх;

6¹.1.5.хуульд заасан бусад бүрэн эрх.”

2 дугаар зүйл.Автотээврийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2 дахь заалтын “, хэрэгжүүлэх” гэснийг, 8 дугаар зүйлийн 8.2, 8.3 дахь хэсэг, 15 дугаар

зүйлийн 15.2 дахь хэсгийн “төв” гэснийг тус тус хассугай.

3 дугаар зүйл.Автотээврийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.1.3, 6.1.8 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

4 дүгээр зүйл.Энэ хуулийг батлагдсан өдрөөс нь буюу 2008 оны 12 дугаар сарын 19-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ДЭМБЭРЭЛ